

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/14/СТА-ТӨҮГ

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	2
1 Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10. Зорилтот түвшиний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
2 Менежментийн захидал.....	12
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
3.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	17
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
/төгрөг/.....	18
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
3.5 Аудит хийсэн зорилтот түвшиний гүйцэтгэлийн тайлан.....	21

## Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЭНХЦЭЦЭГ  
ТАНАА

2019.03.15 № 06/447  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

“Дулаан Шарын гол” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 1 Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Энхцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшиний гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшиний хэрэгжилт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дулаан Шарын гол” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 15-наас 2019 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн Аудитын багийн удирдагч Н.Цэрэнханд, аудитор С.Галсанчоймбол нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшиний гүйцэтгэлийн тайланг Цэгцтөв богд аудит ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/49 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд төсвийн тухай хуулийн цаглабарт хугацааг 6 хоногоор хоцроосон.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад, дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Дулаан Шарын гол” ТӨХК нь дүрэмдээ “хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн дулааны эрчим хүч, ундны цэвэр усаар тасралтгүй найдвартай хангаж, бохир усыг ариутган татан зайлуулах ба эдийн засгийн үр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг хангаж ажиллахад оршино” гэж заасны дагуу үйл ажиллагааны зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

“Дулаан Шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан дүрэмд “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, цэвэр ус олборлох, түгээх, бохир ус татан зайлуулах, суурин газрын ус хангамжийн худаг, ус түгээх цэг, зөөврийн ус хангамж болон орон сууцны барилга байгууламжийн цэвэр, бохир ус, дулаан цахилгааны шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төв, ус хангамж, ариутгал татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ үзүүлэх.



“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн удирдлага дараах хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төлөвлөгөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай
- Усны тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй байна.

Иймд Эрчим хүчний яамнаас гаргасан болон өөрийн боловсруулан мөрдөж байгаа бодлогын баримт бичгийн зарим заалт, шинэчлэгдсэн эрхийн актуудын талаар өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-ийн хурлаар авч хэлэлцэн 2019 онд шинэчлэх шийдвэр гарган ажиллаж байна.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, зорилтот түвшиний гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогоороо зардлаа нөхөж ажиллах зарчимтай байгууллага учир АДБОУС1320, АОУС 320-ыг үндэслэн сонгосон болно.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн Нийт орлого 2,904.5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 58.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь гүйцэтгэлийн үе шатны эрсдэлийн үнэлгээтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.



Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(сая.төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	38.5	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	6.4	
3	Албан шаардлага	1	10.9	
	Дүн	6	55,8	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.1.1.Зардлын данстай холбоотой асуудал.**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 2.7 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.12, Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-т “Аудитаар орлого бүрдүүлэх, зарцуулах, өмч, хөрөнгө бэлтгэх, ашиглах, хадгалах харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актууд болон гэрээ, хэлцлийн нөхцлийг мөрдөөгүйгээс илэрсэн дараах зөрчилд төрийн аудитын байгууллага акт тогтооно. Үүнд: 3.1.3-т Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон” гэж заасны дагуу буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх акт тогтоох

**2.8.1.2. Балансын данстай холбоотой асуудал.**

Монгол улсын дээд шүүхийн шийдвэрээр ажилдаа эргүүлэн томилогдохоор тогтоогдсон ажилтанд ажилгүй байсан хугацааны 3.7 сая төгрөгийн нөхөн олговрыг байгууллагаас олгосон. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны

байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.12, Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-т “Аудитаар орлого бүрдүүлэх, зарцуулах, өмч, хөрөнгө бэлтгэх, ашиглах, хадгалах харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актууд болон гэрээ, хэлцлийн нөхцлийг мөрдөөгүйгээс илэрсэн дараах зөрчилд төрийн аудитын байгууллага акт тогтооно. Үүнд: 3.1.7-д Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэж заасны дагуу акт тогтоох.

#### **2.8.1.3. Авлагатай холбоотой асуудал.**

Авлагын дансны 19 байгууллагатай холбоотой 10.9 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэж заасныг зөрчсөн байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.12, Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-т “Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын дүнд шалгагдагч байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзсэн дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө. Үүнд 4.1.4-т “Байгууллага, иргэдтэй үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй” гэж заасны дагуу авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага өгөх.

#### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг Дархан уул аймгийн үнэлгээчин Агваансүрэнгийн Мөнхцэцэг гүйцэтгэсэн бөгөөд барилга 537.4 сая, байгууламж 274.6 сая, нийтийн эзэмшлийн байгууламж 11.6 сая, эзэмших эрхтэй газар 89.3 сая нийт 912.9 сая төгрөгийн хөрөнгөнд үнэлгээ хийж тайлан гаргажээ. Мөн үлдэх өртөггүй цаашид ашиглах боломжтой 25.5 сая төгрөгийн хөдлөх хөрөнгөнд дахин үнэлгээ хийсэн байна.

## **2.10. Зорилтот түвшиний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зорилтын саналыг, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасныг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төрийн өмчит байгууллагын удирдлага нь батлагдсан зорилтот түвшин, түүний хэрэгжилтийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 16 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,281.4 сая төгрөгийн зорилтот түвшиний зардал батлагджээ. Батлагдсан зорилтот түвшиний зардал, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Зорилтот түвшин, зардлын төлөвлөгөөний нийт гүйцэтгэл 3,168.9 сая төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь удирдлагын болон урсгал зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянахад Эрчим хүчний яамнаас хөрөнгө оруулалт, болон бусад гэсэн дэд цэс-ийг мэдээлж байхаар чиглэл өгсөний дагуу мэдээлж, эрчим хүчний яамны дотоод хяналтаар хангалттай гэсэн үнэлгээ өгч байгаа гэсэн тайлбар хийж Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2.1-д “Байгууллага бүр өөрийн цахим хуудсанд шилэн дансны цэстэй байх бөгөөд шилэн дансны цэс нь 1) Төсөв/гүйцэтгэл; 2) Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт; 3) Бусад; 4) Сангийн яамны мэдээлэл гэсэн дөрвөн дэд цэстэй байна гэж заасны Төсөв/гүйцэтгэл гэсэн дэд цэс-д заагдсан мэдээллүүдийг мэдээлээгүй байна.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар манай аудитын компанийн өгсөн 6 зөвлөмжөөс 5 зөвлөмжийг бүрэн, 100 хувь хэрэгжсэн, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа хэрэгжилт 84 хувь байна.

Авлагын .. сая төгрөгийн эзэн холбогдогч нь эрэн сурвалжлагдаж байгаа болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## **2 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **3.1 Бараа материалтай холбоотой асуудал**

#### **3.1.1 Бараа материалын анхан шатны бүртгэл хөтлөлт**

##### **3.1.1.1 Илрүүлэлт:**

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн маягтыг бүрэн хөтлөөгүй, гарын үсгийн бүрдэл дутуу баримтаар 4.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, мөн хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

##### **3.1.1.2 Эрсдэл:**

Хууль, журам зөрчигдөх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

##### **3.1.1.3 Зөвлөмж:**

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягтуудыг анхан шатны бүртгэл хөтлөлтдөө ашиглах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

#### **3.1.1.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:**

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

#### **3.1.2 Бараа материал**

##### **3.1.2.1 Илрүүлэлт:**

Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон комисс 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр тооллогыг дуусгаж, тооллого явагдсанаас хойш орлого, зарлагын гүйлгээ гарсан байхад тооцоо бодолтонд үр дүнг бүрэн тусгаагүй тайлангийн үлдэгдлээр тооцоог бодсон байна. Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдэл хангагдаагүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

##### **3.1.2.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх, хөрөнгө үрэгдэх

##### **3.1.2.3 Зөвлөмж:**

Хөрөнгийн тооцоо бодохдоо байвал зохих үлдэгдлийг тооллогоор байгаа үлдэгдэлтэй харьцуулан тооцоог бодож, тооцоо бодсон актны маягтад тайлбар тодруулгыг хийж үр дүнг бүртгэлд тусгах

#### **3.1.2.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:**

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

#### **3.2. Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 8.9 сая төгрөгийн өртөгтэй насос CD160/45 бүртгэлтэй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### **3.2.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлангийн “хэмжилт” батламж мэдэгдэл хангагдахгүй байх

##### **3.2.3 Зөвлөмж**

Үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж НББОУС 16-ийн 52-т “үл хөдлөх хөрөнгө, барилга, төхөөрмжийн ашиглагдах хугацааг дахин хянан үзэж болох...” гэж заасны дагуу цаашид ашиглах жилийг хянан үзэж шийдвэрлэн бүртгэх



### **3.2.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:**

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

## **3.3 Нийгмийн даатгалтай холбоотой асуудал**

### **3.3.1 Илрүүлэлт:**

Ажиллагсдад олгосон үр дүнгийн урамшуулалд ногдох нийгмийн даатгалын шимтгэл 21.6 сая төгрөгийг тооцож өглөг дансанд бүртгэсэн ч нийгмийн даатгалын тайланд тусгаагүй тайлагнаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүйгээс гадна нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

### **3.3.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хэрэгжээгүй, алданги торгууль хүлээх эрсдэлтэй

### **3.3.3 Зөвлөмж:**

Хуулийн заалтыг хэрэгжүүлж нийгмийн даатгалын тайланд тайлагнаж төлөх үүргээ биелүүлэх.

### **3.3.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:**

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/Төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2018	12/31/2018
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	18774569.30	249278.42
1.1.2	Дансны авлага	356526874.03	326551260.22
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	123897503.52	152315797.57
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1619448.00	3167947.39
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>500818434.85</b>	<b>482284283.60</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1450532278.32	6632781242.59
1.2.2	Биет бус хөрөнгө	6289408.19	105208658.97
1.2.3	Биологийн хөрөнгө	3230000.00	3230000.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1460051686.51</b>	<b>6741219901.56</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1960870121.36</b>	<b>7223504185.16</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	984741519.91	871638813.91
2.1.1.2	Цалингийн өглөг		67892793.69
2.1.1.3	Татварын өр	207350598.98	284858452.39
2.1.1.4	НДШ–ийн өглөг	154589926.64	118531494.79
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	1346682045.53	1342921554.78
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		119700000.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	1346682045.53	1462621554.78
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат	2272713862.35	6525993994.35
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		849125687.82
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		89304000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-2958538796.68	-1703541051.79
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	614188075.85	5760882630.38
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	1960870121.38	7223504185.16

### 3.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/Төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	2455246615.21	2904550506.05
2	Борлуулалтын өртөг	2447377976.56	2973214643.08
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>7868638.65</b>	<b>68664137.03</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	1087101.95	1320427.86
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	61487372.72	217991199.51
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	101931621.99	129212065.29
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	52004472.88	66318647.56
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-83492981.55</b>	<b>-44883222.51</b>
19	Орлогын татварын зардал		132042.78
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-83492981.55</b>	<b>-45015265.29</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-83492981.55</b>	<b>-45015265.29</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,827,685,955.68</b>	<b>2,096,497,734.24</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,323,474,502.62	1,589,196,238.24
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар	46,008,266.62	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	458,203,186.44	507,301,4796.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,802,289,909.45</b>	<b>1,987,193,452.98</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	853,489,681.06	936,875,022.81
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	137,900,000.00	332,529,584.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	352,278,269.32	314,586,394.11
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	253,236,605.00	81,488,776.40
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	37,789,365.04	57,562,369.97
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	148,372,991.57	225,220,455.92
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		2,442,058.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	19,222,997.46	36,488,791.77
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>25,396,046.23</b>	<b>109,304,281.26</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,087,101.95</b>	<b>1,320,427.86</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,087,101.95	1,320,427.86
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>37,597,500.00</b>	<b>248,850,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	37,597,500.00	248,850,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-36,510,398.05	-247,529,572.14
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		119,700,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		119,700,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	119,700,000.00
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-11,114,351.82	-18,525,290.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,888,922.12	18,744,569.30
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,744,569.30	249,278.42



### 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад хэсэг	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,272,713,862.35</b>	<b>12,160,756.82</b>	-2,874,937,104.94	1,487,852,253.36	897,789,767.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-200,000,000.00	-200,000,000.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-83,601,691.74		-83,601,691.74
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,272,713,862.35</b>	<b>12,160,756.82</b>	<b>-2,958,538,796.68</b>	<b>1,287,852,253.36</b>	<b>614,188,075.85</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-12,160,756.82	1,300,013,010.18	-1,287,852,253.36	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>4,253,280,132.00</b>	<b>0.00</b>	<b>-1,658,525,786.50</b>	<b>0.00</b>	<b>2,594,754,345.50</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		849,125,687.82		89,304,000.00	938,429,687.82
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-45,015,265.29		-45,015,265.29
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,525,993,994.35</b>	<b>849,125,687.82</b>	<b>-1,703,541,051.79</b>	<b>89,304,000.00</b>	<b>5,760,882,630.38</b>

### 3.5 Аудит хийсэн зорилтот түвшиний гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	/төгрөг/ Зөрүү	
						Дүн	Хувь
1	үйлдвэрлэх дулаан эрчим хүч	(г/кал)	39,775.3	41,294.6	37,667.1	(3,627.5)	91.2
	Дотоод хэрэгцээ ДЭХ	(г/кал)	2,884.5	3,220.0	3,220.0	-	100.0
	Түгээлт ДЭХ	(г/кал)	36,890.8	37,074.6	34,447.1	(2,627.5)	92.9
2	Олборлох ус	м3	448,354.0	470,496.0	422,097.0	(48,399.0)	89.7
	Үүнээс: Нэмэлт усны зарцуулалт	м3	25,159.0	28,700.0	26,103.0	(2,597.0)	91.0
	Гал түймэр унтраа-хад хэрэглэх ус	м3	100.0	100.0	100.0	-	100.0
	Борлуулах ус	м3	332,764.3	357,006.7	319,916.5	(37,090.2)	89.6
3	Зайлуулах бохир ус	м3	316,126.1	339,156.4	342,402.0	3,245.6	101.0
4	Нийт орлого	төг	2,063,275,635.50	2,619,596,300.00	2,669,316,678.87	49,720,378.87	101.9
	Үндсэн үйл ажиллагааны борлуулалт	төг	2,000,701,160.70	2,465,007,600.00	2,450,005,051.50	(15,002,548.50)	99.4
5	Нийт зардал	төг	2,601,422,781.62	3,281,424,400.00	3,168,877,398.71	112,547,001.29	96.6
	Үүнээс: Удирдлагын зардал	төг	60,643,100.00	79,930,600.00	78,683,228.46	1,247,371.54	98.4
6	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	төг	(538,147,146.12)	(661,828,100.00)	(499,560,719.84)	162,267,380.26	75.5
7	Төсвийн татаас	төг	454,545,454.55	500,000,000.00	454,545,454.55	45,454,545.45	90.9
8	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	төг	<b>(83,601,691.57)</b>	<b>(161,828,100.00)</b>	<b>(45,015,265.29)</b>	116,812,834.71	27.8
	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.26	1.25	1.19	(0.1)	94.8
9	Ажиллагсдын тоо	төг	117	117	117	-	100.0
10	Нийт цалингийн сан	төг	1,087,248.30	1,191,656,238.00	1,151,346,452.00	(40,309,786.00)	96.6
11	Нэг ажилтны дундаж цалин	төг	721.20	848,758.00	820,047.33	(28,710.67)	96.6
12	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төг/гкал	51,018.15	63,999.92	67,843.98	3,844.06	106.0
13	Жишмэл түлшний хувийн зарцуулалт(кг/Гкал)	(кг/гкал)	188.1	189.8	205.8	16.0	108.4
14	Нийт өр төлбөр	төг	1,346,682,045.53	812,629,200.00	1,462,621,554.78	649,992,354.78	180.0
15	Нийт авлага	төг	356,526,874.03	109,373,300.00	326,551,260.22	217,177,960.22	298.6

2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙН ХҮСНЭГТ

N	Алдаа, зөрчлийн утга	Нийт зөрчил			Хариуцах эзэн		
		Акт тавих	Албан шаардлага	Зөвлөмж	Нийт дүн	Албан тушаал	Нэр
1	Бараа материалын анхан шатны баримтанд зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зураагүй			Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягтуудыг анхан шатны бүртгэл хөтлөлтдөө ашиглах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах	4.5	Ерөнхий нягтлан бодогч	Ж.Даш
	Хөрөнгийн тооллогыг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөр дуусгаж, тооллого явагдсанаас хойш гарсан гүйлгээний дүнгээр тооллогын бүртгэлээс зөрүү үүссэн байхад тооцоо бодсон актад тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримт-жуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.			Хөрөнгийн тооцоо бодохдоо байвал зохих үлдэгдлийг тооллогоор байгаа үлдэг-дэлтэй харьцуулан тооцоог бодож, тооцоо бодсон актны маягтад тайлбар тодруулгыг хийж үр дүнг бүртгэлд тусгах зөвлөмж өгөх	3.5	Ерөнхий нягтлан бодогч	Ж.Даш
2	Авлагын оны эцсийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.		Авлагын үлдэгдлийг харилцагчидтай тооцоо нийлж актаар баталгаажуулах албан шаардлага өгөх		10.9	Ерөнхий нягтлан бодогч	Ж.Даш
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн.	Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.12, Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-т "Аудитаар орлого бүрдүүлэх, зарцуулах, өмч, хөрөнгө бэлтгэх, ашиглах, хадгалах харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актууд болон гэрээ, хэлцлийн нөхцлийг мөрдөөгүйгээс илэрсэн дараах зөрчилд төрийн аудитын байгууллага акт тогтооно. Үүнд: 3.1.3-т Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон" гэж заасны дагуу акт тогтоох			2.7	Гүйцэтгэх захирл	Б.Энхцэцэг
4	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн CD160/45 насос ашиглагдаж байна.			Үлдэх өртөггүй ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг цаашид ашиглах бол	8.9	Гүйцэтгэх захирал	Б.Энхцэцэг

Дулаан шарын гол ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

			дахин үнэлгээ хийлгэх эсэхийг шийдвэрлүүлэх зөвлөмж			
5	Монгол улсын дээд шүүхийн шийдвэрээр ажилдаа эргүүлэн тогтоогдсон ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг байгууллагаас олгож, гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулаагүй зөрчил илэрсэн.	Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.12, Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-т "Аудитаар орлого бүрдүүлэх, зарцуулах, өмч, хөрөнгө бэлтгэх, ашиглах, хадгалах харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актууд болон гэрээ, хэлцлийн нөхцлийг мөрддөггүйгээс илэрсэн дараах зөрчилд төрийн аудитын байгууллага акт тогтооно гэж заасны дагуу төлбөрийн акт тогтоох		3.7	Гүйцэтгэх захирал	Б.Энхцэцэг
6	Ажиллагсдад олгосон үр дүнгийн урамшуулалд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд тусгаагүй тайлагнаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүйгээс гадна нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.		Хуулийн заалтыг хэрэгжүүлж нийгмийн даатгалын тайланд тайлагнаж төлөх үүргээ биелүүлэх.	21.6	Ерөнхий нягтлан бодогч	Ж.Даш
	Дүн			55.8		